



НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН
ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/УЗ

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгө данснаас
хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны 05 сарын 12-ны өдрийн А/72 тоот тушаал, Төвийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 07 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 516,164,353.14 (таван зуун арван зургаан сая, нэг зуун жаран дөрвөн мянга, гурван зуун тавин гурван төгрөг, арван дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасах ажлыг төвийн өмч хамгаалах Байнгын зөвлөл болон Санхүүгийн албатай хамтран зохион байгуулж, ажлын үр дүнг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Авто бааз, аж ахуй хариуцсан орлогч дарга (Ц.Тамир)-т үүрэг болгосугай.

2. Данснаас хасагдаж буй 75 нэр төрлийн 502,647,352.14 (таван зуун хоёр сая зургаан зуун дөчин долоон мянга гурван зуун тавин хоёр төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 8 нэр төрлийн 9,129,900 (есөн сая нэг зуун хорин есөн мянга есөн зуун) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөх, 10 нэр төрлийн 4,387,101 (дөрвөн сая гурван зуун наян долоон мянга нэг зуун нэг) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 170,000 (нэг зуун далан мянган) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 51,000 (тавин нэг мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Б.Сэргэлэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.АРИУНБОЛД